



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Сургалт зохион байгуулах тухай" А/1145 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Монголд зочлох жил"-ийн хүрээнд аялал жуулчлал өндөр хөгжсөн оронд суралцсан тогооч нарын ур чадвар, мэдлэг туршлага хуваалцах "Олон улсын хоолны жор технологи" сэдэвт сургалтыг Улаанбаатар хотын зочлох үйлчилгээний байгууллага, зоогийн газрын тогооч нарыг хамруулан 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсугай.

2. Сургалт зохион байгуулахад шаардагдах хавсралтанд дурьдсан 31,000,000 (Гучин нэгэн сая) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг агентлаг хариуцсан Ахлах нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Сургалт зохион байгуулах удирдамж батлуулан нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



83

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2024 оны 10 дугаар сарын 01 өдрийн
11/4 дугаар тушаалын хавсралт

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зардлын зүйл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1.	Танхимын түрээсийн төлбөр	Өдөр	1.5	6,000,000	9,000,000
2.	Хоолны материал, татан авалтын зардал	Багц	1	14,000,000	14,000,000
3.	Сургагч багшийн ажлын хөлс	Хүн	8	400,000	3,200,000
4.	Бэлтгэгч тогооч нарын ажлын хөлс	Хүн	8	150,000	1,200,000
5.	Сургалтын мэдээллийг дэлгэц рүү цацах холболтын ажлын хөлс	Багц	1	1,000,000	1,000,000
6.	Оролцогчийн сертификат, хоолны технологи карт хэвлэх зардал	Багц	200	13,000	2,600,000
ДҮН:					31,000,000